



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2025 оны 07 сарын 21

Улаанбаатар хот

Нэг. Хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

Зам, тээврийн яамны, төлөвлөлтийн газар /БТГ/-ын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

БТГ-ын 2025 оны үйл ажиллагааг 2025 оны эхний хагас жилийн байдлаар Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, ЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайд, ТНБД-ын тушаалын биелэлт гэсэн 5 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **78.26%**-тай байна.

Эдгээрийг тусад нь авч үзвэл:

2.1. БТГ-ын 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт	Үүнээс							Биелэлтийн хувь
	100%	90%	70%	50%	30%	0%	Хугацаа болоогүй	
42	28	5	4	2	3	-	-	88.6%

2.2. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт

Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн явц зорилтот түвшин					Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
	85 хувь буюу түүнээс дээш “үр дүнтэй”	60-84 хувь буюу “үр дүн хүлээгдэж байгаа”	30-59 хувь буюу “үр дүн хангалтгүй”	0-29 хувь буюу “үр дүн гараагүй”			
2	-	-	2	-	-	-	41.5%

2.4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:

Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн явц зорилтот түвшин			Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	
41	34	4	3	89.5%

2.5. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт:

Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн явц зорилтот түвшин			Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	
10	8	2	-	80%

Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт:

Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн явц зорилтот түвшин			Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	
14	11	1	2	91.7%

Гурав: Үнэлэлт, дүгнэлт
1.Төлөвлөлтийн байдал:

Бодлого, төлөвлөлтийн газар 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа яамны төлөвлөгөөнд туссан арга хэмжээ түүний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинтэй уялдуулан төлөвлөсөн боловч Яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 9.8 “Эрдэм шинжилгээ, судалгаа болон лабораторийн туршилт, шинжилгээний дүгнэлт гаргах ажлуудыг бодлого арга зүйгээр хангана”, 9.9.“Салбарын цахимжуулалтын төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг хангана” гэсэн арга хэмжээг Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаагүй байна. Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 42 арга хэмжээний нийт ажлын 29 буюу 69.4 хувийг жилийн турш, 4 арга хэмжээ буюу 9.5 хувийг эхний хагас жилд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн байна.

Бүтцийн өөрчлөлт хийгдсэн болон Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам” шинэчлэн батлагдсантай холбоотой яамны зохион байгуулалтын бүтцийн нэгж болон харьяа байгууллагуудын Гүйцэтгэлийн төлөвлөгөөний суурь болон зорилтот түвшинг тоо, хувиар илэрхийлж болохуйцаар шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

2.Хэрэгжилтийн байдал:

1) БТГ-ын 2025 оны үйл ажиллагааг 2025 оны эхний хагас жилийн байдлаар Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайд, ТНБД-ын тушаалын биелэлт гэсэн 5 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **78.26%**-тай байна. Эдгээрээс Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт **41.5%**-тай үнэлэгдсэн байна.

3) БТГ-ын Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 33 арга хэмжээ буюу 78,5% нь эхний хагас жилд хүрэх түвшиндээ хүрсэн болон хэрэгжих шатанд, 9 арга хэмжээ буюу 21,5% нь төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй байна.

4) Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилтуудаар нь авч үзвэл:

№	Зорилтууд	Арга хэмжээний тоо	Хэрэгжилт
1	Зорилт 1. Зам, тээврийн салбарын үйл ажиллагааг өргөжүүлэх, нэгдсэн бодлогын төсөл, төлөвлөлтийг боловсруулж, бодлогын удирдамжаар хангана.	20	87%
2	Зорилт 2. Салбарын стандарт, норм, нормативыг боловсронгуй болгох үйл ажиллагааг зохион байгуулах, бодлогын удирдамжаар хангана.	12	96.7%

3	Зорилт 3. Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх, цахим үйлчилгээг боловсронгуй болгох бодлогын удирдамжаар хангах;	10	82%
---	---	----	-----

5) БТГ-ын 2025 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт **68.7%**-тай байсан бол хоёрдугаар улирлын байдлаар **88.6%**, болж, өмнөх улирлаас 28.96 хувиар өссөн дүнтэй байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний улирлын хэрэгжилтийн хяналт-шинжилгээний мөрөөр өгсөн санал зөвлөмжөөс дараах арга хэмжээний хэрэгжилт ахисан байна. Үүнд:

- ✓ Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зам, тээврийн салбарын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эзэнжүүлсэн төлөвлөгөө;
 - ✓ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын “5.1”-д *“Байгууллагын бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгж бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн, хяналт-шинжилгээний асуудал хариуцсан нэгж, ажилтан (баг)-д тогтоосон хугацаанд хүргүүлэх”* гэж заасан тул энэхүү арга хэмжээг эрчимжүүлж ажиллах;
 - ✓ Яамнаас 2025 онд УИХ, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөө;
 - ✓ “Монголд зочлох жил”-ийн салбарын 2025 оны төлөвлөгөө;
 - ✓ Авто замын салбарын норм, дүрэм, техникийн баримт бичгийг боловсруулж, батлуулах, салбарын бүтээгдэхүүн үйлчилгээнд тохирлын үнэлгээний итгэмжлэл, баталгаажуулалт хийлгэх үйл ажиллагааг эрчимжүүлэх;
 - ✓ Салбарын төсөл, хөтөлбөрийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл оруулах ажлыг зохион байгуулах, салбарт хэрэгжүүлж буй бүтээн байгуулалтын төслүүдийн явцыг зайнаас цахимаар хянах шинэ төсөл, Зорчигчдын замын хөдөлгөөний аюулгүй байдлыг олон улс, улсын чанартай авто замыг сүлжээнд хангах радио долгионы суваг нээх судалгааны ажил, салбарын бүтээмжийг нэмэгдүүлэхэд процессын дахин инженерчлэлийг нэвтрүүлэх судалгааны ажил.
- Дараах зөвлөмжүүд хэрэгжээгүй, удаашралтай хэвээр байна. Үүнд:
- ✓ Зам, тээврийн салбарын залуучуудыг дэмжих 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө;
 - ✓ Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэх үйлдвэр, үйлчилгээг 2025 онд хөгжүүлэх төлөвлөгөө;
 - ✓ “Салбарын хүний нөөцийн сургалтын хэрэгцээг тодорхойлж, сургалтыг зохион байгуулах арга хэмжээ.

6) Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан Зам, тээврийн сайдын хариуцан гүйцэтгэх болон холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх арга хэмжээ тус бүрийг эзэнжүүлээгүй тул БТГ, ТЗУГ болон холбогдох бусад газрын хэрэгжүүлэх арга хэмжээ тодорхой бус тул үнэлэлт өгч, хэрэгжилтийг тооцоход бэрхшээлтэй байна.

Дөрөв. Санал, зөвлөмж

Бодлого, төлөвлөлтийн газрын 2025 оны үйл ажиллагаанд эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дараах санал, зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

4.1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан Зам, тээврийн салбарын залуучуудыг дэмжих 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэх үйлдвэр, үйлчилгээг 2025 онд хөгжүүлэх төлөвлөгөө, “Салбарын хүний нөөцийн сургалтын хэрэгцээг тодорхойлж, сургалтыг зохион байгуулах арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэн ажиллах;

4.2. Бүтцийн өөрчлөлт хийгдсэн, Хяналт-шинжилгээ, үнэлгээний журамд өөрчлөлт орсонтой холбогдуулан Яам, Газар, Хэлтэс болон Харьяа байгууллагын шинэчлэн батлуулах Гүйцэтгэлийн төлөвлөгөөний арга хэмжээний суурь болон зорилтот түвшинг тоо,

хувиар илэрхийлж болохуйцаар шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, улирал бүрээр хүрэх боломжтой, бодитой төлөвлөлт хийхэд дэмжлэг үзүүлэх.

4.3. Шинээр батлагдсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээний журам”-аар Бодлогын баримт бичиг, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэх аргачлалд өөрчлөлт орж, тайлагнах хугацаа, биелэлтийн явцын үр дүнгээр Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх тул Дээд газрын үүрэг даалгавар, шийдвэрийн хэрэгжилтийг тухай бүр чанартай, үнэн зөв, бүрэн тайлагнах;

4.4. Мөн Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлж, Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ажилласан, Гадаад, дотоод томилолтоор ажилласан тохиолдолд холбогдох журамд заасан хугацаанд хийсэн ажлын тайланг гаргаж, хэвших;

4.5. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангах ажлын хүрээнд Яамны газар, хэлтэс, харьяа байгууллагын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэн, эзэнжүүлэх төлөвлөгөө, шийдвэрийг албажуулан, холбогдох бусад бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим систем (new.unelgee.gov.mn)-д хууль тогтоомжид заасан хугацаанд нэгтгэн, тайлагнаж хамтран ажиллахыг тус тус зөвлөж байна.

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР**

**ЗТЯ-НЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН**

/Хүснэгтээр/

№	Хяналтад байх арга хэмжээ	2025 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/	Хэрэгжилтийн хувь
1	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	42	42	88.6%
2	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт	2	2	41.5%
3	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	41	41	89.5%
4	Сайдын тушаалын биелэлт	10	10	80%
5	ТНБД-ын тушаалын биелэлт	14	14	91.7%
Нийт		109	109	78.26%

**ЗТЯ-НЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН 2025 ОНЫ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН**

/Графикаар/

